



**ХАЛДВАРТ ӨВЧИН
СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2022 оны 09 сарын 30 өдөр

Дугаар А/232

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1 дэх хэсэг, 45.2.1 дэх заалт, 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, 47 дугаар зүйлийн 47.1, 47.3, 47.4 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5 дахь заалт, Ерөнхий захирлын 2021 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн “Журам батлах тухай” А/100 дугаар тушаалын 4 дүгээр зүйлийн 4.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус төвийн Насанд хүрэгчдийн цочмог гепатитын тасгийн цонх солих ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах тендерийн үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Дарга:	Н.Батням – Хангамж үйлчилгээ, инженерийн технологийн албаны дарга
Нарийн бичгийн дарга:	А.Шинэхүү – Эдийн засагч
Гишүүд:	Д.Баярсайхан – Стратеги төлөвлөлт, гадаад харилцаа эрхэлсэн дэд захирал Н.Батжаргал – Худалдан авах ажиллагааны хөтөч ТББ-ын багш /зөвшилцсөнөөр/ Б.Алтангэрэл - Эрүүл мэндийн эдийн засгийн хөгжил ТББ-ын гишүүн /зөвшилцсөнөөр/

2. Үнэлгээний хорооны гишүүдийг дэмжлэгт удирдлагаар ханган ажиллаж, худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, Үнэлгээний хорооны зөвлөмж, дүгнэлтийг Захиалагчид хугацаанд нь ирүүлэхийг Үнэлгээний хорооны дарга (Н.Батням)-д, Үнэлгээний хорооны үйл ажиллагаа хэвийн явагдах нөхцлийг

бүрдүүлж, үйл ажиллагааны явцад хөтлөгдөх баримт бичгийг зохих заавар, журмын дагуу зохион бүрдүүлж, хариуцлагатай ажиллахыг Нарийн бичгийн дарга (А.Шинэхүү)-д тус тус даалгасугай.

3. Үнэлгээний хороонд ажиллахдаа авилга, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг баримтлан хууль дээдлэн, шударга ажиллахыг Үнэлгээний хорооны нийт бүрэлдэхүүнд үүрэг болгосугай

4. Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд орж ажилласан Төрийн бус байгууллагын гишүүдэд олгох урамшууллыг тооцон Худалдан авах ажиллагааны орлогоос, олгохыг Санхүү бүртгэлийн албаны дарга (Г.Хунзаяа)-д зөвшөөрсүгэй.

5. Энэ тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хүний нөөцийн албаны дарга (Ж.Баярсайхан)-д үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Ц.БИЛЭГТСАЙХАН